БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2024/175/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Х.Еркебулан<br>Утас: 99427667 Цахим хаяг: erkebulankh@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 2
Асуудлыг онцолсон хэсэг ........ **Error! Bookmark not defined.**
Аудитын гол асуудал ........ **Error! Bookmark not defined.**
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ **Error! Bookmark not defined.**
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 15
4.1 Ерөнхий зүйл ........ 15
4.2 Материаллаг байдал ........ 15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 16
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2024.02.28 № 242

танай ______________-ны № ______________-т

НОГООННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Т.ЕРТАЙ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

**Аудитын гол асуудал**

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал

00402229

байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ЭК.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **61,136,297.50** | **71,571,827.50** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 61,136,297.50 | 71,571,827.50 |
| **354** | **Хангамжийн материал** | 41,036,297.50 | 51,471,827.50 |
| 35420 | Аж ахуйн материал | 23,979,173.00 | 28,969,173.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 392,364.50 | 5,837,894.50 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 16,664,760.00 | 16,664,760.00 |
| 35600 | Мал амьтад | 20,100,000.00 | 20,100,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,116,885,932.26** | **3,993,625,557.17** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,116,885,932.26 | 3,993,625,557.17 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,111,633,932.26 | 3,986,670,318.17 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 762,436,870.00 | 804,875,974.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (112,339,911.72) | (145,246,325.52) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 357,203,962.80 | 321,398,435.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (236,374,966.64) | (189,509,897.30) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 124,097,451.00 | 179,832,143.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (94,896,908.60) | (86,715,492.62) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 73,549,236.00 | 83,491,736.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (48,359,169.46) | (48,392,111.16) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 4,676,488,996.10 | 4,714,423,332.10 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (1,391,805,227.22) | (1,649,121,075.33) |
| 39217 | Ном | 1,633,600.00 | 1,633,600.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 5,252,000.00 | 6,955,239.00 |
| 39301 | Программ хангамж | 2,513,400.00 | 2,509,639.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,513,400.00) | (1,086,400.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5,252,000.00 | 5,532,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,178,022,229.76** | **4,065,197,384.67** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **18,088,046.00** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 18,088,046.00 | - |
| **413** | **Өглөг** | 18,088,046.00 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 18,088,046.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,159,934,183.76** | **4,065,197,384.67** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,159,934,183.76 | 4,065,197,384.67 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 832,907,694.44 | 833,187,694.44 |
| 51101 | Өмч: - төрийн | 832,907,694.44 | 833,187,694.44 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,442,039,179.18 | 2,360,106,280.09 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,442,039,179.18 | 2,455,123,079.18 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (95,016,799.09) |

| | | | |
|---|---|---|---|
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 884,987,310.14 | 871,903,410.14 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,178,022,229.76** | **4,065,197,384.67** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **721,399,442.00** | **1,231,482,910.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **60,390,600.00** | **276,650,925.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 18,856,000.00 | 276,650,925.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | - | 267,400,925.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 18,856,000.00 | 9,250,000.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 41,534,600.00 | - |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 41,534,600.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **661,008,842.00** | **954,831,985.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 155,792,242.00 | - |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 155,792,242.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,390,600.00 | 10,696,285.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,147,000.00 | 4,413,834.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,243,600.00 | 6,282,451.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 500,826,000.00 | 944,135,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 500,826,000.00 | 944,135,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **952,940,764.04** | **1,326,499,709.09** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **952,940,764.04** | **1,326,499,709.09** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 888,375,564.04 | 1,318,660,297.09 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 355,633,128.00 | 530,076,566.83 |
| 210101 | Үндсэн цалин | 237,592,404.00 | 370,841,813.00 |
| 210102 | Нэмэгдэл | 58,337,800.00 | 121,014,746.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 59,702,924.00 | 38,220,007.83 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,651,718.00 | 67,780,991.17 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,702,518.00 | 67,780,991.17 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,237,300.00 | - |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,589,900.00 | - |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 647,400.00 | - |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,474,600.00 | - |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,972,219.80 | 16,211,413.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 865,000.00 | 4,934,458.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 11,107,219.80 | 11,276,955.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,953,500.00 | 92,665,791.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,719,300.00 | 4,126,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,827,500.00 | 83,371,391.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,318,700.00 | 4,770,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 88,000.00 | 397,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 457,000.00 | 2,930,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 457,000.00 | 2,930,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 25,323,740.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 2,998,440.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 22,325,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 9,690,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 9,690,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,938,400.00 | 32,095,060.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,796,500.00 | 30,511,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 362,200.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 90,300.00 | 92,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 184,900.00 | 399,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 75,000.00 | 85,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 307,200.00 | 838,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 37,300.00 | 123,760.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 85,000.00 | 45,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 435,769,598.24 | 541,886,735.09 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,236,600.00 | 99,712,435.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 274,900.00 | 1,733,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 393,258,098.24 | 440,441,300.09 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 64,565,200.00 | 7,839,412.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 41,534,600.00 | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 41,534,600.00 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,030,600.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 23,030,600.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 7,839,412.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 7,839,412.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(231,541,322.04)** | **(95,016,799.09)** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(231,541,322.04)** | **(95,016,799.09)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **546,751,200.00** | **954,831,985.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **41,534,600.00** | **-** |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | **41,534,600.00** | **-** |
| **123002** | **Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого** | **41,534,600.00** | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **505,216,600.00** | **954,831,985.00** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,390,600.00 | 10,696,285.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,147,000.00 | 4,413,834.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,243,600.00 | 6,282,451.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **500,826,000.00** | **944,135,700.00** |
| **132001** | **Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/** | **500,826,000.00** | **944,135,700.00** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **546,751,200.00** | **905,331,985.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **546,751,200.00** | **905,331,985.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **482,186,000.00** | **897,492,573.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **343,730,400.00** | **557,672,506.00** |
| 210101 | Үндсэн цалин | 227,403,800.00 | 336,841,813.00 |
| 210102 | Нэмэгдэл | 58,337,800.00 | 121,014,746.00 |
| 210104 | Урамшуулал | | 4,815,947.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 57,988,800.00 | 95,000,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **40,466,400.00** | **58,273,098.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,517,200.00 | 35,825,599.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,237,300.00 | 5,611,899.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,589,900.00 | 4,489,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 647,400.00 | 1,122,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,474,600.00 | 11,223,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **10,585,000.00** | **21,664,985.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 865,000.00 | 7,125,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,720,000.00 | 14,539,985.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **22,784,500.00** | **76,265,149.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,797,000.00 | 3,420,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,580,800.00 | 67,747,249.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,318,700.00 | 4,770,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 88,000.00 | 327,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **457,000.00** | **2,930,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 457,000.00 | 2,930,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,543,400.00** | **36,169,440.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 2,998,440.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 71,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,543,400.00 | 33,100,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,866,100.00** | **9,690,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,866,100.00 | 9,690,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,962,600.00** | **34,059,860.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,729,200.00 | 32,395,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 362,200.00 | 80,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 90,300.00 | 92,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 184,900.00 | 399,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 75,000.00 | 85,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 398,700.00 | 838,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 37,300.00 | 123,760.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 85,000.00 | 45,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **46,790,600.00** | **100,767,535.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,390,600.00 | 98,628,535.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 400,000.00 | 2,139,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **64,565,200.00** | **7,839,412.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **41,534,600.00** | **-** |
| **213101** | **Засгийн газрын дотоод шилжүүлэг** | **41,534,600.00** | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **23,030,600.00** | **-** |
| **213205** | **Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал** | **23,030,600.00** | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **-** | **7,839,412.00** |
| **213403** | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | | **7,839,412.00** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **49,500,000.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **49,500,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **49,500,000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 49,500,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 49,500,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(49,500,000.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 832,907,694.44 | 884,987,310.14 | 2,442,039,179.18 | 4,159,934,183.76 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **832,907,694.44** | **884,987,310.14** | **2,442,039,179.18** | 4,159,934,183.76 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **832,907,694.44** | **884,987,310.14** | **2,442,039,179.18** | 4,159,934,183.76 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **832,907,694.44** | **884,987,310.14** | **2,442,039,179.18** | 4,159,934,183.76 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **832,907,694.44** | **884,987,310.14** | **2,442,039,179.18** | 4,159,934,183.76 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 832,907,694.44 | 884,987,310.14 | 2,455,123,079.18 | 4,173,018,083.76 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 280,000.00 | (13,083,900.00) | | (12,803,900.00) |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (95,016,799.09) | (95,016,799.09) |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **833,187,694.44** | **871,903,410.14** | **2,360,106,280.09** | 4,065,197,384.67 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,032,996,100.00** | **936,996,289.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,032,996,100.00** | **936,996,289.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,015,173,700.00** | **936,996,289.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **561,184,100.00** | **557,672,506.00** |
| 210101 | Үндсэн цалин | 338,692,600.00 | 336,841,813.00 |
| 210102 | Нэмэгдэл | 122,491,500.00 | 121,014,746.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 5,000,000.00 | 4,815,947.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 95,000,000.00 | 95,000,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **58,273,100.00** | **58,273,098.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,825,600.00 | 35,825,599.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,611,900.00 | 5,611,899.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,489,500.00 | 4,489,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,122,400.00 | 1,122,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,223,700.00 | 11,223,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **21,665,000.00** | **21,664,985.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,125,000.00 | 7,125,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 14,540,000.00 | 14,539,985.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **74,140,000.00** | **74,140,000.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,420,000.00 | 3,420,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 65,622,100.00 | 65,622,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,770,900.00 | 4,770,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 327,000.00 | 327,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **2,930,000.00** | **2,930,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,930,000.00 | 2,930,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **73,885,000.00** | **55,169,440.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 34,714,000.00 | 21,998,440.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 71,000.00 | 71,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 39,100,000.00 | 33,100,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **8,989,100.00** | **8,940,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,989,100.00 | 8,940,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **99,509,000.00** | **47,559,860.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 97,184,000.00 | 45,895,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 645,500.00 | 80,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 180,600.00 | 92,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 399,800.00 | 399,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 85,000.00 | 85,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 838,000.00 | 838,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 131,000.00 | 123,760.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 45,100.00 | 45,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **114,598,400.00** | **110,646,400.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 111,884,400.00 | 108,507,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,714,000.00 | 2,139,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **17,822,400.00** | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **17,822,400.00** | - |
| **213207** | **Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж** | **17,108,400.00** | |
| **213209** | **Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал** | **714,000.00** | |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,032,996,100.00** | **936,996,289.00** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,032,996,100.00** | **936,996,289.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **132001** | Орон нутгийн төсвөөс | 1,032,996,100.00 | 936,996,289.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** |
| **610001** | **Төсвийн байгууллага** | **1.00** | **1.00** |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **32.00** | **41.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 13.00 | 13.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 12.00 | 12.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2.00 | 2.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 5.00 | 14.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **32.00** | **41.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9.00 | 9.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 5.00 | 5.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 5.00 | 14.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 13.00 | 13.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **10,696,285.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **10,696,285.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 10,696,285.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,125,149.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,125,149.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 750,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 750,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,121,135.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,121,135.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **700,001.00** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 700,001.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 10,696,285.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 10,696,285.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,413,834.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,282,451.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар нь Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй, үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж, мөрдөн, дотоод ажлыг сайжруулна. Ажлын цагийн ашиглалтыг сайжруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажлын хөнгөн шуурхай байдлыг хангана. Байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдлыг хангаж ажиллана гэсэн эрхэм зорилго дэвшүүлсэн ажилласан байна.

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар нь Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар нь 2023 онд дотоод аудитын шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/07 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 113.1 сая төгрөгөөр буюу 9.7 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | **1** | **2** | **3=2-1** |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 61,136.3 | 71,571.8 | 10,435.5 |
| Үндсэн хөрөнгө | 4,116,885.9 | 3,993,625.6 | (123,260.3) |
| **Нийт хөрөнгө** | **4,178,022.2** | **4,065,197.4** | **(112,824.8)** |
| Өр төлбөр | 18,088.0 | - | (18,088.0) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 4,160,214.2 | 4,065,197.4 | (95,016.8) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **4,178,302.2** | **4,065,197.4** | **(113,104.8)** |

Мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа дансанд  өөрчлөлт гараагүй бол бараа материалын дансанд бага дүнтэй, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын данс 10.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Байгаль хамгаалагч болон нөхөрлөлийн 4 улирлын дүрэмт хувцсыг орлогод авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 123.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 49.5 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймаг, сумын ОНХС-гаас бүгд 250.4 сая төгрөгийн ухаалаг дэлгэц, гүний худаг, ванн, мобикомын интернет сүлжээний машин, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн Төрийн өмчийн газраас Лексус-470

маркийн авто машиныг шилжүүлэн авч, аймгийн ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 156 тоот тогтоолоор 117.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан. Үндсэн хөрөнгөд 440.4 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өглөг дансны эхний үлдэгдэл 18.1 сая төгрөгийн өр төлбөртэй бүрэн барагдуулсан байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 95.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр зарлагын нийт дүнг 944.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас урсгал засварын зардал 38.0 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 50.0 сая төгрөгөөр нийтдээ 88.0 сая төгрөгөөр нэмж, 1032.9 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 88.0 сая төгрөгөөр нэмэгдэж, 1032.9 сая төгрөгөөр тодотгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1032.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжилт авахаар тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 936.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, төлөвлөснөөс 88.9 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, жилийн эцэст 7.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 936.9 сая төгрөг буюу 90.7 хувьтай байна. Үндсэн үйл ажиллагааны зардлаас 4.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны зардлаас 2.2 сая бүгд 7.1 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 730,955.5 | 707,407.7 | 23,547.8 | 96.8% |
| 2 | Туслах үйл ажиллагааны зардал | 158,118.2 | 154,690.6 | 3,427.6 | 97.8% |
| 3 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 17,822.4 | 0 | 17,822.4 | 0% |
| 4 | Орон нутгийн нөөц хөрөнгө | 30,000.0 | 30,000.0 | 0 | 100% |
| 5 | Байгаль орчныг хамгаалах, нөхөх сэргээх зардал | 96,100.0 | 44,900.0 | 51,200.0 | 46.7% |
| | **Дүн** | **1,032,996.1** | **936,998.3** | **95.997.8** | **90.7** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар нь аймгийн Статистикийн газраас хагас жилийн тооллогын зардалд 3.8 сая төгрөгийн, ШШГГ-аас 5.7 сая төгрөгийн, аймгийн ЗДТГ-аас сургалтын зардалд 0.6 сая төгрөгийн, 0.6 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орж, нийтдээ 10.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч тээвэр шатахуун, томилолт, бараа үйлчилгээний бусад зардалд 10.0 сая төгрөгийг зарцуулж, жилийн эцэст 0.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/17 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 359.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,326.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 19.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор нэмэгдэл цалин, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, хичээл үйлдвэрийн дадлага хийх зардлыг нийтдээ 7.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 2,265.6 сая төгрөгийн 11 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 282.3 сая төгрөгийн 24 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 11.5 сая төгрөгийн 3 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар эхний хагас жилийн баримтыг хүлээн авч түүвэр сорил хийсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 71.6 сая төгрөгийн албан шаардлага өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 3 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 1 | 71.6 | 1 | 71.6 | 100 |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **71.6** | **1** | **71.6** | 100 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж аудитаар санхүүгийн тайлан гаргалт, эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Орон нутгийн төсвөөс болон ОНХС-гаас авсан санхүүжилтийн зарцуулалтын тооцоог гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар нийт 11.9 сая төгрөгийн зөрчил[1] илэрч 11.9 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар дараах зөрчилд албан шаардлага өгөгдлөө. Үүнд:

1.Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар нь “Бектолхын” ХХК, “Их цэнгэл эрчим” ХХК, “Өндөр нарийн гол” ХХК-аас нийтдээ 49,500.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төрийн цахим худалдан авалтын тухай хууль тогтоомжийг зөрчиж худалдан авсан зөрчилд албан шаардлага өгөв.

*Энэ нь* Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.13-т “Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т ”Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэсэн заалтуудыг *зөрчсөн байна.*

Шийдвэрлэсэн нь:Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*1.1.Илрүүлэлт:*

Цалингийн зардлын төсвөөс ажилтнуудад 11.9 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцээгүй байна.

*1.2. Өгсөн зөвлөмж*:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

*Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

<table>
<tr><th rowspan="3">Алдааны товч утга</th><th colspan="2" rowspan="2">Нийт алдаа</th><th colspan="2" rowspan="2">Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан</th><th colspan="2" rowspan="2">Буруу тусган илэрхийлсэн</th><th colspan="4">Үүнээс</th><th colspan="2" rowspan="2">Зөвлөмж</th></tr>
<tr><th colspan="2">Залруулсан</th><th colspan="2">Залруулаагүй</th></tr>
<tr><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Дүн</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

<table>
<tr><th rowspan="2">Зөрчлийн товч утга</th><th rowspan="2">Нийт зөрчил</th><th colspan="5">Үүнээс</th></tr>
<tr><th>Төлбөрийн акт</th><th>Албан шаардлага</th><th>Зөвлөмж</th><th>Хариуцлага тооцуулах албан шаардлага</th><th>Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал</th></tr>
</table>

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Цалингийн зардлаас түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон | 1 | 11,992.0 | | | | | 1 | 11,992.0 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **11,992.0** | | | | | **1** | **11,992.0** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төрийн цахим худалдан авалтын журам зөрчсөн | 1 | 49,500.0 | | | 1 | 49,500.0 | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **49,500.0** | | | **1** | **49,500.0** | | |